



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ДАЛАЙН ЗАХИРГАА ТӨҮГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/29/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: bolor-erdened@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа уул аудит ХХК
Захирал Ч.Мөнхтуяа Цахим хаяг: uwaaauul.audit@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
5.1 Шилэн дансны мэдээлэл	12
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
8. Аудитын илрүүлэлт	14
8.1 Залруулсан алдаа	14
8.2 Төлбөрийн акт	14
8.4 Зөвлөмж	14
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗТХЯ	Зам, тээвэр хөгжлийн яам
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай



ДАЛАЙН ЗАХИРГАА ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ Б.БИНДЭРЪЯА ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/567
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын тайлан

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Далайн захиргаа ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Далайн захиргаа ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тайлант онд орлогыг 662.5 сая төгрөгөөр, зардлыг 2,426.6 сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр 1,612.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,386.2 сая төгрөгийн зардал гарган, 226.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 93.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,966,058,211.50	2,216,302,225.75
1.1.4	Бусад авлага	32,610.46	
1.1.6	Бараа материал	104,808,381.00	123,465,019.30
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	282,000.00	2,757,888.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,071,181,202.96	2,342,525,133.05
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,086,549,001.18	1,041,382,760.38
1.2.2	Биет бус хөрөнгө	18,810,500.00	19,232,500.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	190,192,000.00	190,192,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,295,551,501.18	1,250,807,260.38
1.3	Нийт хөрөнгийн дүн	3,366,732,704.14	3,593,332,393.43
	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3	Өмч		
2.3.1	-төрийн	231,164,305.84	231,164,305.84
2.3.2	-хувийн		
2.3.3	-хувьцаат		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	62,460.00	62,460.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	3,135,505,938.30	3,362,105,627.59
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,366,732,704.14	3,593,332,393.43
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	3,366,732,704.14	3,593,332,393.43

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,153,381,462.76	1,676,619,305.36
2	Борлуулалтын өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)	2,153,381,462.76	1,676,619,305.36
5	Хүүний орлого	11,455,265.84	
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,370,272,658.41	1,448,382,958.88
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	53,290,574.77	1,183,200.33
14	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	(45,080,738.11)	(2,819,857.52)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	802,773,906.85	226,599,689.29
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	802,773,906.85	226,599,689.29
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	231,164,305.84	62,460.00	2,332,732,031.45	2,563,958,797.29
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл				
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			802,773,906.85	802,773,906.85
Бусад дэлгэрэнгүй орлого				
2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	231,164,305.84	62,460.00	3,135,505,938.30	3,366,732,704.14
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
Залруулсан үлдэгдэл				
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			226,599,689.290	226,599,689.29
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	231,164,305.84	62,460.00	3,362,105,627.59	3,593,332,393.43

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1	Мөнгөн орлогын дүн	2,160,730,539.79	1,636,578,087.76
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,153,381,462.76	1,609,811,852.46
1.1.6	Бусад мөнгөн орлого	7,349,077.03	26,766,235.30
1.2	Мөнгөн зарлагын дүн	1,321,500,506.72	1,373,785,516.32
1.2.1	Ажиллагчдад төлсөн	660,061,663.44	653,892,097.05
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	81,501,010.02	82,316,781.83
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	49,626,948.27	54,234,000.95
1.2.9	Бусад мөнгөн зарлага	530,310,884.99	583,342,636.49
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	839,230,033.07	262,792,571.44
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.1	Мөнгөн орлогын дүн	11,455,265.84	-
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	11,455,265.84	
2.2	Мөнгөн зарлагын дүн	177,315,495.00	10,911,900.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	177,315,495.00	10,911,900.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(165,860,229.16)	(10,911,900.00)
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
3.1	Мөнгөн орлогын дүн	53,290,574.77	1,183,200.33
3.1.4	Валютын ханшийн зөрүү	53,290,574.77	1,183,200.33
3.2	Мөнгөн зарлагын дүн		2,819,857.52
3.2.5	Валютын ханшийн зөрүү		2,819,857.52
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	53,290,574.77	(1,636,657.19)
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	726,660,378.68	250,244,014.25
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,239,397,832.82	1,966,058,211.50
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,966,058,211.50	2,216,302,225.75

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
A	Нийт орлого	2,153,381.5	2,628,558.2	3,578,826.1	950,267.9	136.2
1	Үндсэн үйл ажиллагааны орлого /Хөлөг онгоцны бүртгэлийн хураамж/	2,153,381.5	660,000.0	1,609,811.9	949,811.9	243.9
2	Бусад орлого /Усан замын тээврийн оношилгоо, үзлэгийн орлого/	-	2,500.0	2,956.0	456.0	118.2
3	Дансны үлдэгдэл	-	1,966,058.2	1,966,058.2	-	100.0
Б	Нийт зардал	1,574,122.4	2,426,559.0	1,386,168.2	1,040,390.8	57.1
1	Ерөнхий ба удирдлагын зардал	1,370,272.7	1,705,278.9	1,350,044.6	355,234.3	79.2
2	Цалин	660,796.2	740,526.0	653,892.1	86,633.9	88.3
3	НДШ	82,114.0	99,971.1	82,316.8	17,654.3	82.3
4	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,094.6	54,534.6	49,574.6	4,960.0	90.9
5	Хангамж бараа материалын зардал	88,752.4	80,020.0	54,234.0	25,786.0	67.8
6	Томилолт, зочны зардал	12,317.9	59,500.0	29,699.8	29,800.2	49.9
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	34,008.2	359,279.1	189,004.9	170,274.2	52.6
8	Бараа үйлчилгээний бусад зардал	197,939.3	3,600.0	3,546.0	54.0	98.5
9	Бусад урсгал шилжүүлэг	15,250.0	30,000.0	24,640.0	5,360.0	82.1
10	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	15,000.0	14,529.6	470.4	96.9
11	Эд хогшил, урсгал засвар	-	32,848.1	15,393.5	17,454.6	46.9
12	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	223,000.0	230,000.0	230,000.0	-	100.0
B	Хөрөнгө оруулалт	203,849.7	721,280.1	36,123.6	685,156.5	5.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Далайн захиргаа ТӨҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудалд аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгө, бараа материалын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Уваа уул Аудит ХХК-ийн аудитор Б.Буяндэлгэр, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанар хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Далайн захиргаа ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан Уваа уул аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 1/33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь дотоод аудитын нэгжгүй, тайлант онд Зам, тээвэр хөгжлийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, ТӨБЗГ-ын хууль эрх зүй, хяналт, дотоод аудитын хэлтсээс шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Далайн захиргаа ТӨҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузул сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1,370.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 13.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Далайн захиргаа ТӨҮГ-ын зорилго нь “Үндэсний хөлөг онгоц, багийн гишүүдтэй болж Монгол Улсын экспорт, импортын бараа бүтээгдэхүүнийг далайн найдвартай гарцаар гуравдагч зах зээлд саадгүй тээвэрлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх”-д оршино

Далайн захиргаа ТӨҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг усан замын тээврийн бүртгэл, хяналт, хөлөг онгоцны бүртгэл, далайн боомт ашиглалт, үндэсний боловсон хүчин бэлтгэх ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн 9070002084 дугаартай гэрчилгээнд төрийн байгууллага, албан газар гэсэн статустай байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Далайн захиргаа ТӨҮГ нь Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2007 оны 174 дүгээр тушаалаар байгуулагдсан байна. Энэ нь Далай ашиглах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу Далайн захиргааг байгуулах, өөрчлөх, татан буулгах, удирдлагыг нь томилох асуудлыг тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ гэсэн заалттай нийцэж байна.

Далайн захиргаа ТӨҮГ нь төлөөлөн удирдах зөвлөлгүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ шинэчлэн батлах тухай”

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Далайн захиргаа ТӨҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,966,058.2	2,216,302.2	250,244.0
Авлага	32.6	-	(32.6)
Урьдчилгаа	282.0	2,757.9	2,475.9
Бараа материал	104,808.4	123,465.0	18,656.6
Урт хугацаат хөрөнгө оруулалт	190,192.0	190,192.0	-
Үндсэн хөрөнгө	1,105,359.5	1,060,615.3	(44,744.2)
Нийт хөрөнгийн дүн	3,366,732.7	3,593,332.4	226,599.7
Эздийн өмч	3,366,732.7	3,593,332.4	226,599.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,366,732.7	3,593,332.4	226,599.7

Харилцах дансанд байгаа мөнгөний үлдэгдэлд Төрийн банк дахь 2,216.3 сая төгрөг байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэлд тайлант онд автомашины зогсоолын төлбөрт төлсөн 1.8 сая төгрөг, албан томилолтын урьдчилгааны 0.9 сая төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 123.5 сая төгрөг болж 18.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны худалдан авалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс 44.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардлаас шалтгаалан буурсан байна.

Эздийн өмч 3,593.3 сая төгрөг болж 226.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Далайн захиргаа ТӨҮГ-ын захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/73 дугаар тушаалаар Далайн захиргаа ТӨҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны үйл ажиллагааны орлогыг 662.5 сая төгрөг, өмнөх оны дансны үлдэгдэл 1,966.1 сая төгрөг, нийт 2,628.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, нийт зардлыг 2,426.6 сая төгрөг байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын 12 арга хэмжээнд 721.3 сая төгрөг, улсын төсөвт төвлөрүүлэх орлого 230.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,676.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,450.0 сая төгрөгийн зардал гарган, 226.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 1,612.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 950.3 сая төгрөг буюу 143.4 хувиар давсан нь тайлант оны орлогыг үндэслэлгүй багаар төлөвлөснөөс шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,450.0 сая төгрөг болж, төлөвлөснөөс 976.6 сая төгрөг буюу 57.0 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд хөрөнгө оруулалтын зардал, цалин хөлс, бараа үйлчилгээний зардлыг хэмнэсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 6 ажилд өөрийн эх үүсвэрээс 36.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Монгол улсын “2021 оны төсвийн тухай” хуулийн 3.13 дахь заалтын дагуу тайлант онд 230.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Далайн захиргаа ТӨҮГ нь тайлант онд нийт 2,008.0 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 510.7 сая төгрөгийн 19 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн

6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан тул албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд худалдан авах ажиллагааны цахим системд 1 удаагийн 14.0 сая төгрөгийн тендерийн мэдээллээ байршуулж "Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам"-ыг мөрдөж ажилласан байна.

Засгийн газраас авч хэрэгжүүлсэн хэмнэлтийн горимыг зөрчин 10.4 сая төгрөгийн тавилга эд хогшил, 14.5 сая төгрөгийн албаны хувцас худалдан авсан нь 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4. "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага өгөх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын холбогдох заалттай нийцээгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 104.3 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 104.3 сая төгрөгийг алдааг залруулж зөрчлийг арилгасан байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.7 сая төгрөгийн төлбөрийн актын биелэлт 100.0 хувь, 73.2 сая төгрөгийн 1 албан шаардлагын биелэлт 75.0 хувь, 12.0 сая төгрөгийн 3 зөвлөмжийн биелэлт 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	700.0	1	700.0			100.0
Албан шаардлага	1	73,200.0	1	73,200.0	1		75.0
Зөвлөмж	3	12,000.0	3	12,000.0			100.0
Нийт дүн	5	85,900.0	5	85,900.0			91.6

Шилэн дансны нэгдсэн системд 2 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан зөрчил давтан гаргасан тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацаанд байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 81.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 66.2 сая төгрөгийн 4 алдааг залруулж, 15.3 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй алдаа зөрчлийн дүн 15.3 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 13.7 сая төгрөгөөс хэтэрсэн боловч 15.3 сая төгрөгийн төлбөрийн акт төлөгдсөнөөр санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл бага тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- 2021 оны эхний үлдэгдэл 0.03 сая төгрөгийн авлагыг хааж зардалд бичсэн;
- Үндсэн хөрөнгийн элэгдлийг 10.1 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
- Петростар ХХК-аас авсан шатахууны хөнгөлөлт 0.6 сая төгрөгийг бүртгэлд тусгаагүй;
- Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө 55.4 сая төгрөгийг байгууллагын үйл ажиллагааны орлогоор бүртгэснийг.

8.2 Төлбөрийн акт

Тайлант онд нэр бүхий 8 хүнд 11.8 сая төгрөгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол 1.3."төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолыг зөрчиж урамшуулал олгосон тул төлбөрийн акт тогтоох.

Тус байгууллага нь зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 3.5 сая төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол 1.3."төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолыг зөрчиж зочин төлөөлөгч хүлээн авах зардал гаргасан тул төлбөрийн акт тогтоох.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 44.8 сая төгрөгийн хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ТӨБЗГ-аас ашиглах жил, үнэ шинэчлэн тогтоох зөвшөөрөл авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын дансанд 31.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэсэн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” журмын 2.2. Төрийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй боловч үндсэн хөрөнгийн шинжийг агуулаагүй, элэгдэл байгуулахад тохиромжгүй хөрөнгийг эргэлтийн хөрөнгийн дансанд шилжүүлэх, эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, үндсэн хөрөнгийн шинжийг агуулсан хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэх, үндсэн хөрөнгийн дансны ангилал хооронд шилжүүлэх асуудлыг судлан, тухай бүр зөвшөөрөл олгож байх” гэж заасантай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ТӨБЗГ-аас дансны ангилал хооронд шилжүүлэх зөвшөөрөл авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Далайн захиргаа ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан**

				ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх												
8	Далайн захиргаа ТӨҮГ	АХГ-2022/26/НА-СТА-ТӨА	Бараа материалын дансанд 31.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэсэн	Хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ТӨБЗГ-аас дансны ангилал хооронд шилжүүлэх зөвшөөрөл авч тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	-									1	-
ДҮН					8	81,541.3	4	66,210.1	2	15,331.2	0	0	0	0	2	-
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Далайн захиргаа ТӨҮГ	АХГ-2022/26/НА-СТА-ТӨА	Тайлант онд нийт 2.008 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 510.7 сая төгрөгийн 19 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.	1	-					1	-				
2	Далайн захиргаа ТӨҮГ	АХГ-2022/26/НА-СТА-ТӨА	МУЗГ-аас авч хэрэгжүүлсэн хэмнэлтийн горимыг зөрчин 10.4 сая төгрөгийн тавилга эд хогшил, 14.5 сая төгрөгийн албаны хувцас худалдан авсан	Засгийн газрын 43 дугаар тогтоолыг зөрчсөн тул албан шаардлага өгөх.	1	24,900.0					1	24,900.0				
ДҮН					2	24,900.0	-	-	-	-	2	24,900.0	-	-	-	-
НИЙТ ДҮН					10	106,441.3	4	66,210.1	2	15,331.2	2	24,900.0	-	-	2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 75/А0150458

Улаанбаатар хот

АХГ-2022/29/НА-СТА ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Далайн захиргаа ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зочин төлөөлөгч хүлээн авах зардалд 3,500,000.00 төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол 1.3."төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Зочин төлөөлөгч хүлээн авахад зарцуулсан 3,500,000.00 /гурван сая таван зуун мянган/ төгрөгийг буруутай албан тушаалтнуудаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Далайн захиргаа ТӨҮГ-ын захирал Б.Биндэръяа, ерөнхий нягтлан бодогч Ш.Азмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ч.МӨНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 76/20150458
АХГ-2020/29/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Далайн захиргаа ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд нэр бүхий 8 хүнд 11,800,000.00 төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол 1.3."төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тайлант онд нэр бүхий 8 хүнд олгосон нийт 11,800,000.00 /арван нэгэн сая найман зуун мянган/ төгрөгийг буруутай албан тушаалтнуудаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкн дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар-т ирүүлэхийг Далайн захиргаа ТӨҮГ-ын захирал Б.Биндэръяа, ерөнхий нягтлан бодогч Ш.Азмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Ч.МӨНХТУЯА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 397/20150458

Улаанбаатар хот

АХГ-2022/29/МД-СТА-ТӨМ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Далайн захиргаа ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансанд байршуулбал зохих 149 мэдээллээс 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтсон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4 "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж байх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Далайн захиргаа ТӨҮГ-ын захирал Б.Биндэръяа, ерөнхий нягтлан бодогч Ш.Азмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ч.МӨНХТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 396/АД/150458

Улаанбаатар хот

АХГ-2022/29/НА-СТА ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Далайн захиргаа ТӨҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 10,400,000.00 төгрөгийн тавилга эд хогшил, 14,500,00.00 төгрөгийн албаны хувцас худалдан авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4. "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, зориулалт бус зардал гаргахгүй байх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Далайн захиргаа ТӨҮГ-ын захирал Б.Биндэръяа, ерөнхий нягтлан бодогч Ш.Азмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Ч.МӨНХТУЯА



